

Америк судлал ба Монгол

1. Америк судлалаархи Улаанбаатарын бага хурал

1997 оны тавдугаар сарын 8,9-нд Улаанбаатар хотноо Монголын АНУ судлалын Төв, Монгол дахь Америкийн мэдээллийн алба хамтран “Америк судлал ба Монгол” сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг бэлдэж хийв.

Бага хуралд монголын америк судлалын төвийн гишүүд, Гадаад харилцааны дээд сургууль, Гадаад хэлний дээд сургуулийн америк судлал, англи хэлний мэргэжилтэн нараас гадна Монгол Улсын Их хурал дахь Монгол-Америкийн парламентын бүлгийн дарга, Их Хурлын хүндэт гишүүн С.Болдхэт, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдыг түр хамаарагч, эрхэмсэг хатагтай Ллиуилин Хэжбэт, АНУ-ын Мэдээллийн албаны Улаанбаатар дахь төлөөлөгч, хатагтай Анн Дрисколл, АНУ-ын Мэдээллийн албаны америк судлалын хөтөлбөр хариуцагч хатагтай Иля Ром -Хопкинс, Энэтгэгийн Хайдарабад хот дахь Америк судлалын төвийн дарга, доктор Ричард Бэрг гэргийн хамт, Сеул хотын Соганы их сургуулийн хүндэт профессор Ким Ён Хвон, Тайландын Чулалонканы их сургуулийн багш, доктор Прани Тиларат, Хятадын Ланьжоугийн их сургуульд залагдан багшилж буй Мэри Эллэн Хэйн Шмидер, АНУ-ын Ютагийн их сургуулийн багш доктор Жексон, доктор Роймс, доктор Томас, доктор Уолквист, Монгол дахь АНУ-ын А-гийн сангийн самбарын даамал, доктор Шелдон Северинхаус, Монгол дахь Соросын сангийн захирал Ноён Христофер Финч Монгол Улсын Гадаад

харилцааны Яамны Ази, Америкийн хэлтсийн эрхлэгч, элчин сайд ноён Л.Даваагийв, ШУА-ийн дэд ерөнхийлөгч профессор Б.Энхтүвшин, нийгмийн ухаан хариуцсан тэргүүлэгч гишүүн академич С.Норовсамбуу, Түүхийн Хүрээлэнгийн захирал А.Очир, тус хүрээлэнгийн Олон улс судлалын төвийн удирдлагаас дэд доктор С.Дашпэвэл, профессор Х.Дашдондов нарын зэрэг хүмүүс уригдан оролцжээ.

Бага хурлыг Монголын АНУ судлалын тэргүүн профессор, академич Н.Ишжамц товч үг хэлж нээв. Түүнчлэн Улаанбаатар дахь АНУ-ын хэргийг түр хамаарагч хагагтай Ллиуиллин Хэжбэт, Монгол Улсын УИХ дахь Монгол-АНУ-ын парламент хоорондын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн С.Болдхэт нар үг хэлэв.

Тус хуралд "Монгол дахь америк судлалын үүсэл, байдал" илтгэлийг Монголын АНУ судлалын төвийн тэргүүн профессор Н.Ишжамц тавив. Хуралд нийт америк судлал, Монголд түүний үүсэн хөгжиж буй байдлын талаар АНУ, БНХАУ, Гонконг, Тайланд, БНСолонгос улс, Энэтхэг, Монголын эрдэмтэд судалгаа, шинжилгээ, онол-арга зүй, сурвалж, мэдээллийн ач холбогдол бүхий чухал хориод илтгэл, тавьсаныг ихээхэн сонирхон сонсч, ул суурьтай шүүмжилж хэлэлцжээ.

Энэхүү хурал америк судлалын мөн чанар, өвөрмөц онцлог ба нийтлэг шинж, түүний онол-арга зүйн үндсийг лавшруулан манай америк судлагчдад үнэтэй цэнэтэй хувь нэмэр болно.